

---

## МЦХ ХК-ИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

---

### Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 30-ний өдөр зохион байгуулагдлаа. Хурлын ирц: 95.46%.

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлээ. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай
5. ТУЗ-ийн 2018 оны зардлын төсвийг батлах тухай
6. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай
7. Үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах тухай

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэр

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9991 хувийн саналаар батлав.
2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9968 хувийн саналаар батлав.
3. Компанийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт, Аудитын хорооны дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9968 хувийн саналаар батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг 99.9970 хувийн саналаар батлав.
6. Үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах асуудлыг 99.9951 хувийн саналаар батлав.

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тухай

Компанийн одоо мөрдөгдөж байгаа дүрмийг 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн баталсан байдаг. Компанийн нийт хувьцааны хяналтын багц эзэмшигч БНСУ-ын Кореа телеком корпорацийн 40 хувийг Монгол Улсын Засгийн газар худалдан авсантай холбоотой ТУЗ-ийн гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэх заалтууд, мөн компанийн тухай хуулийн 84.2-д “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна.” гэж заасантай холбоотой заалтуудыг тус тус

компанийн дүрэмд нэмж оруулах шаардлагатай болж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр компанийн төв байранд хуралдсан бөгөөд хурлын ирц 94.71 % байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцлээ.  
Үүнд:

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг батлах тухай
2. Орон сууц хувьчлах тухай

#### **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр:**

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар баталж,
  - Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хавсралт ёсоор батлав.
  - Нэмэлт, өөрчлөлт оруулсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.
2. Орон сууц хувьчлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

#### **Төлөөлөн удирдах зөвлөл**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг (1/3) нь хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг.

2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж, сонгосон бөгөөд ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

#### **ТУЗ-ийн дарга**

#### **Ердийн гишүүд**



**Ц.БАЯР-ЭРДЭНЭ**  
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга



**Г.ЭРДЭНЭБУЛГАН**  
ЗГ-ийн хэрэг эрхлэх газар, Хууль, эрхзүйн газар, Засгийн газрын референт



**Ж.ЦОГТБАЯР**  
СЯ, СХЭУГ-ын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга



Ч.ЦЭВЭГДОРЖ  
Үндэсний Статистикийн  
Хороо,  
Тамгын газрын дарга



Д.АРИУНТУЯА  
ХЗДХЯ, Захиргааны хэм  
хэмжээний актын хяналт,  
бүртгэлийн хэлтсийн дарга



Т.ЛХАГВАСҮРЭН  
Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газар,  
Бодлого төлөвлөлт,  
удирдлагын хэлтсийн  
мэргэжилтэн

### ХАРААТ БУС ГИШҮҮД



Ж.ТАМИР  
Төр засгийн үйлчилгээ эрхлэх  
газрын дарга



Л.БОЛОРМАА  
Төрийн банк, Хүний  
нөөцийн газрын захирал



Ц.НОРОВЖАМЦ  
Интер аудит ХХК-ийн  
гэрээт аудитор

2018 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 9 хурлаар 26 асуудлыг хэлэлцсэн байна. Үүнээс батлагдсан-22, хойшлуулсан-1, танилцуулсан-3 асуудал байна.

Үр дүн: 22 тогтоол, 1 тэмдэглэл гарган гүйцэтгэлийг хангуулан ажилласан байна.

Онцлог асуудал:

- Компанийн тухай хуулийн дагуу компанийн 2017 оны санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж аудит хийлгэлээ.
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хэлэлцүүлэх шийдвэр гаргасан.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдууллаа.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо, Цалин, урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодтой үйл ажиллагаагаа явуулж байна.

2018 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод нийт 8 удаа хуралдаж 8 асуудлыг хэлэлцэж нийт 6 санал дүгнэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2 тогтоолын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулж, нэг тушаал гарган гүйцэтгэх удирдлагад хүргүүлсэн байна.

## 2018 ОНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2018 онд салбарын зах зээлийн орчин, хөгжлийн хандлага, өрсөлдөөний үед байр сууриа хадгалах, цаашид зах зээлийн бодит багтаамжаа тодорхойлох, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллалаа.

### Үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх хувийг тогтоон барих талаар:

- + Суурин утасны 1,991 хэрэглэгч шинээр холбогдож, 4,303 хэрэглэгч гэрээ цуцалсан ба хэрэглэгчийн тооны төлөвлөгөө 95,8%-ийн биелэлттэй, өмнөх оноос 4,7%-иар буурсан хэдий ч суурин утасны үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого өмнөх жилтэй харьцуулбал 19,3%-ийн өсөлттэй гарлаа. 2018 оны байдлаар орон нутагт олон салбартай 85 албан байгууллагуудын суурин утасны 1,585 хэрэглэгч байгаагийн 1,312 нь МЦХ ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг авч байна.
 
- + Интернэтийн 2,079 хэрэглэгч шинээр холбогдож, 2,851 хэрэглэгч гэрээ цуцалж, төлөвлөгөө 92,3%-иар биелж, өмнөх оноос 4,4%-ийн бууралттай байгаа ч нэг хэрэглэгчээс олох дундаж орлого өмнөх онтой харьцуулахад 15,4%-ийн өсөлттэй байлаа. Энэ нь алба хэрэглэгчийн тооны өсөлт болон хэрэглэгчийн хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой.
 
- + Кабелийн телевизийн 2,106 хэрэглэгч шинээр холбогдож, 1,223 хэрэглэгч гэрээ цуцалсан ба хэрэглэгчийн тооны төлөвлөгөө 79,7%-ийн биелэлттэй, өмнөх оноос 12,8%-иар буурсан ч нэг хэрэглэгчээс олох дундаж орлого өмнөх жилээс 80,9%-ийн өссөн байна.
 
- + Үндсэн үйлчилгээний хэрэглэгчийн гэрээ цуцлалт өнгөрсөн онтой харьцуулахад суурин утасны хувьд 3 дахин, интернетийн хувьд 2,5 дахин, кабелийн телевизийн хувьд 1,4 дахин тус тус буурч, нийт цуцлалт, шинэ холболтын харьцаа 1.3:1-д болж байгаа нь хэрэглэгчээ хадгалах эерэг хандлага гарч байна.
- + Лавлах үйлчилгээний нийт дуудлагын тоо төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй ч амралтын өдрийн дуудлагын тоо 667-776 хүртэл нэмэгдсэн. 19001109 шугамаар 423,915 хэрэглэгчийн дуудлага хүлээн авч, нийт дуудлаганд 99,5% амжилттай хариу өгч ажилласан байна.


  
**ҮНДСЭНИЙ ЛАВЛАХ**

### Хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах, сэтгэл ханамжийг дээшлүүлэх талаар:

“Хэрэглэгч - Таны төлөө” уриатай “+1” хөтөлбөрийг орон даяар 3 үе шаттайгаар хэрэгжүүлсэнээр нийт хэрэглэгчийн 40% буюу 7,899 хэрэглэгчдэд урамшуулалт үйлчилгээг хүргэж, суурин утас, интернэт болон кабелийн телевизийн 2,571 хэрэглэгч



шинээр холбож, интернэтийн үйлчилгээний 3,712 албаны, 4,187 хувь хэрэглэгчийн хурдыг нэмэгдүүлжээ.

Нэмэлт үйлчилгээний багцыг шинээр нэвтрүүлэн 1,079 хэрэглэгчид борлуулснаар, суурин утасны нэмэлт үйлчилгээнээс олох орлогыг 33 хувиар өсгөсөн байна. Орон нутгийн албан байгууллагын интернет хэрэглэгчдийн 91%, хувь

хэрэглэгчдийн 80% нь “+1” хөтөлбөрт хамрагдаж, хэрэглэгчийн сэтгэл ханамж сайжирсан судалгааны дүн гарлаа.

Шилэн кабелийн сүлжээ орсон байгууллагуудад GPON сүлжээг хүргэсэнээр өндөр хурдны интернэтийн үйлчилгээг хүргэж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлт 92 хувьд хүрч, оны зорилтот түвшингээс даруй 2 хувиар давлаа.

Техник технологи, сүлжээний ашиглалт үйлчилгээний 8 үзүүлэлтээр гэмтэл саатлыг хянаж, гэмтэл засалтын дундаж хугацааг бууруулахад анхаарч ажилласнаар гэмтэл саатал болон программ хангамжтай холбоотой гомдлууд 29-32 хувь тус тус буурсан.



### Бизнес, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар:

Хамтын ажиллагааны хүрээнд 50 гаруй байгууллагатай техник, технологитой холбоотой тоног төхөөрөмжийн түрээс болон интернэтийн урсгал, сувгийн үйлчилгээ, харилцан холболт, сүлжээ ашиглалтын зэрэг орлого, зардлын 12 нэр төрлийн гэрээ байгуулан ажиллаж байна. Тухайлбал:



- ✚ Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд Боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд интернэт урсгал нийлүүлэх, төрийн өмчийн шилэн кабелийн дэд бүтэц хүрээгүй 53 суманд хот хоорондын тоон сувгийн үйлчилгээ үзүүлэх болон 86 суманд тоног төхөөрөмжийг байрлуулах байр талбай түрээслүүлэх үйлчилгээний гэрээг тус тус хийж, нийтдээ 2 тэрбум орчим төгрөгийн орлогыг төвлөрүүлж, гэрээний дагуу үйлчилгээгээ хүргэж байна.
- ✚ Ази Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын гишүүнчлэлийг сэргээлгэж, хамтын ажиллагааг сайжруулснаар 2018 онд 9,500 орчим ам.долларын өртөгтэй тэтгэлэгт сургалтад 3 хүн хамрагдсан. Мөн АНДЦХБ-ын буцалтгүй тусламжаар орон нутагт интернэт үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад байгалийн эрс тэс уур амьсгал, ажиллагааны хүнд нөхцөлд тэсвэртэй, суурилуулалтын зардал бага шаарддаг, бат бөх чанарын шинэ стандартын шилэн кабелийг ашиглах төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.
- ✚ ХХМТГ-ын дэмжлэгтэйгээр БНЭУ-ын буцалгүй тусламжаар LTE сүлжээний утасгүй интернэтийн туршилтын сүлжээг байгуулах төслийн судалгаа хийгдэж, шийдвэрлэгдэх шатандаа явж байна.
- ✚ Дэлхийд өгөгдлийн сан, үүлэн тооцооллын үйлчилгээгээр тэргүүлэгч Оракл (Oracle Inc.) компанийн Монгол улсыг хариуцсан Москва хот дахь суурин төлөөлөгчийн газартай холбогдон, тус компанийн өгөгдлийн сан, үүлэн тооцооллын үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлэх судалгааны ажлуудыг эхлүүлсэн. Одоогоор өгөгдлийн сангийн лиценз, сервер хостингийн үйлчилгээг нэвтрүүлэх хэлцлийг хийж байна.
- ✚ Facebook компанийн Ази, Монголыг хариуцсан хүмүүстэй албан ёсоор уулзаж ярилцсанаар Монгол улсын нийт сумдад Wifi сүлжээг нэвтрүүлэх төслийг тус компанийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхээр болоод байна.
- ✚ FreeConferenceCall.com компанитай гэрээ байгуулан, олон улс хоорондын яриа болон аудио хурал хийх үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Уг үйлчилгээг ашигласнаар дэлхийн аль ч өнцгөөс МЦХ ХК-ийн суурин утасны дугаарт холбогдон аудио яриа хурал зохион байгуулах боломжтой юм.
- ✚ Японы KDDI, БНСУ-ын КТ корпораци, ОХУ-ын Ростелеком зэрэг улс хоорондын карьеруудтай харилцан холболтын тарифыг шинэчлэн тогтоож гэрээнд тусгаснаар, олон улсын ярианы тариф буурах нөхцлийг бүрдүүллээ.
- ✚ Найдваргүй авлагын эрсдэлийг бууруулах зорилгоор авлагын өндөр насжилттай хэрэглэгчдийг Монгол банкны Зээлийн мэдээллийн санд оруулах гэрээ хийж, цаашид хэрэглэгч төлбөрөө хугацаанд нь төлөх авлага үүсэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн.
- ✚ Хэрэглэгчийн төлбөр тооцооны нэгдсэн системийг шинэчлэх ажилд БНСУ-ын UANGEL корпорацийг гүйцэтгэгчээр шалгаруулан гэрээ байгуулж, төслийн ажил амжилттай хэрэгжиж байна.
- ✚ Төрийн цахим үйлчилгээг иргэдэд нээлттэй, хүртээмжтэй хүргэх, иргэдийг төрийн цахим үйлчилгээнд идэвхтэй оролцуулах зорилтын хүрээнд ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ “ХУР” системийг үйлчилгээндээ нэвтрүүлж, иргэн компанийн үйлчилгээг шуурхай авах боломжтой боллоо.

- ✚ 1900-1109 Үндэсний Лавлах үйлчилгээний дуудлагын тоог нэмэгдүүлэхээр Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв, ЦЕГ-ын бүртгэл хяналтын төвийн мэдээлэл лавлагаа өгөх гэрээ байгуулж хамтран ажиллах болсноор иргэдэд мэдээлэл хүргэж эхэлсэн.
- ✚ Хэрэглэгчид төлбөрөө түргэн шуурхай төлөх нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Төлбөр тооцооны Qray үйлчилгээг нэвтрүүлэн, мөн Хаан банк, Most Money, Худалдаа хөгжлийн банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Богд банк, Чингис хаан банкаар дамжуулан төлбөрөө бэлэн бусаар төлөх боломжтой боллоо.



### Техник технологийн хөгжүүлэлтийн талаар:

2018 онд техник, технологийн өргөтгөл шинэчлэл хийх, ашиглалт үйлчилгээний тасралтгүй найдвартай ажиллагаа хангах чиглэлээр дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✚ Суурин утасны хэрэглэгчдийг дараа үеийн технологид шилжүүлэх ажлын хүрээнд RSU36 станцын 2,550 хэрэглэгч, RSU34 станцын 8,790 хэрэглэгч, RSU379 станцын 417 хэрэглэгч, RSU302 станцын 408 хэрэглэгчдийг NGN станц руу тус тус шилжүүллээ.
- ✚ Дараа төлбөрт үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд урьдчилсан төлбөрт үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлж, гэрээ байгуулснаар төлбөр тооцооны нэгдсэн цогц системийг ашиглалтад оруулах ажлыг хийгдэж байна.
- ✚ Интернэтийн үйлчилгээний шилэн кабелийн GPON сүлжээг өргөтгөж, гол кабелийн параметр муу, интернэтийн хурд удаан, хэрэглэгчдээс гомдол их ирдэг байсан 10 гаруй хуваарилах шүүгээнүүдэд шинээр MSAN суурилуулснаар хэрэглэгчдэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээг хүргэх боломж бүрдсэн.
- ✚ NGN станц нь одоогоор төв станц болон 276 дэд станцтай, 70,422 хэрэглэгчийн багтаамжтай болж, УБ хотод нийт 141 станцтай 44,204 хэрэглэгчийн багтаамжтай, холбогдсон хэрэглэгчийн тоо 31,686, орон нутагт нийт 135

станцтай 26,218 хэрэглэгчийн багтаамжтай, холбогдсон хэрэглэгчийн тоо 18,027 байна.

- Кабелийн телевизийн үйлчилгээг тоон системд бүрэн шилжүүлж, Булган аймгийн төв болон Өвөрхангай аймгийн Хархорин суманд шинээр үйлчилгээ нэвтрүүлэн, Хөвсгөл, Архангай, Говь-сүмбэр аймгуудын тоон телевизийн DVB-T2-



ийн сүлжээний нэвтрүүлэгчид өргөтгөл хийн 5 зөөгчтэй болгосноор үйлчилгээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, сувгийн тоог нэмэгдүүллээ. SPS спорт сувгууд, Гэр контент компанийн ТВ сувгуудыг албан ёсны эрхтэйгээр үзүүлдэг болсноор контентын чанарыг үе шаттай сайжруулж байна.

- Алслагдсан сум суурин газрын Wi-Fi үйлчилгээ, чанарыг сайжруулах, картын борлуулалт, орлогыг нэмэгдүүлэх, нийт тоног төхөөрөмжийн хяналтыг сайжруулах, үйлчилгээний хамрах хүрээ, байршил зэргийг тодорхой болгох зорилгоор тоон станц болон IP сүлжээний үндсэн төхөөрөмжүүдийг төвлөрсөн хяналтад оруулж, WiFi AP-уудын хяналтыг шинээр хийж, 381 төхөөрөмжийг хяналтад оруулснаар нийт 486 access point-с 234 access point-ийг хяналтад авч, access point-уудыг бодит цагийн нарийвчлалтай хянаж, ачааллын судалгааг цаг, өдөр, сар, жилээр гаргах боломж бүрдсэн.
- Шилэн кабелийн 9 чиглэлд 35.62км, GPON сүлжээний 11 болон MSAN шинээр байгуулах 16 чиглэлд 10.38км шилэн кабелийн өргөтгөлийг хийж гүйцэтгэлээ.





## МЦХ ХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

### Орлого

2018 онд 22,909.3 сая төгрөгийн нийт орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 21,193.8 сая төгрөгийн нийт орлоготой ажиллаж, төлөвлөгөө 92.5 хувийн биелэлттэй буюу 1,715.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Үндсэн үйл ажиллагаанаас 21,920.4 сая төгрөгийн орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 19,823.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөө 90.4 хувийн биелэлттэй буюу 2,097.3 сая төгрөгөөр тасарсан.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 39 хувиар буюу 381.7 сая төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй гарсан нь хүүгийн орлого, данснаас хассан үндсэн хөрөнгийн борлуулалт болон бусад орлогын төлөвлөгөө давж биелсэнтэй холбоотой.

### Зардал

2018 онд 22,765.0 сая төгрөгийн нийт зардал төсөвлөж, гүйцэтгэлээр 20,778.2 сая төгрөгийн нийт зардал гарган 91.3 хувийн биелэлттэй буюу 1,987.6 сая төгрөгийн зардал хэмнэсэн үзүүлэлттэй байна.

Үндсэн үйл ажиллааны зардал төлөвлөснөөс 1,939.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн ба үүнд интернэтийн сувгийн түрээс 708.3 сая төгрөг, харилцан холболтын зардал 145.8 сая төгрөг, борлуулсан барааны өртөг 136.3 сая төгрөг, цалин болон НДШ-ийн зардал 655 сая төгрөг, түрээсийн зардал 129.9 сая төгрөгөөр хэмнэсэн, бусад үйл ажиллагааны зардлуудыг төсөвлөсөн дүнгээр зарцуулсан.

### Ашиг

Тайлант хугацаанд 44.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 316.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### 2018 оны санхүүгийн зорилтын биелэлт

/Нэгж: сая төгрөг/

| №  | Үзүүлэлт                          | 2018 оны төлөвлөгөө | 2018 оны гүйцэтгэл | Биелэлт | Зөрүү     |
|----|-----------------------------------|---------------------|--------------------|---------|-----------|
| 1  | Үндсэн үйл ажиллагааны орлого     | 21,920.4            | 19,823.2           | 90.4%   | (2,097.2) |
| 2  | Үндсэн үйл ажиллагааны зардал     | 21,879.1            | 19,939.4           | 91.1%   | (1,939.7) |
| 3  | Үйл ажиллагааны ашиг              | 41.3                | (116.2)            | n/a     | (157.5)   |
| 4  | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 988.9               | 1,370.6            | 138.6%  | 381.7     |
| 5  | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 885.8               | 838.8              | 94.7%   | (47.0)    |
| 6  | ЕВИТДА                            | 3,130.6             | 2,748.1            | 87.8%   | (382.5)   |
| 7  | Элэгдлийн зардал                  | 3,089.3             | 2,864.4            | 92.7%   | (224.9)   |
| 8  | Татварын өмнөх ашиг               | 144.3               | 415.6              | 288.0%  | 271.3     |
| 9  | Орлогын албан татвар              | 100.0               | 99.6               | 99.6%   | (0.4)     |
| 10 | Цэвэр ашиг                        | 44.3                | 316.0              | 713.3%  | 271.7     |

Эх сурвалж: МЦХ ХК, Бизнес төлөвлөлтийн алба

## 2018 ОНЫ АВЛАГА, ӨГЛӨГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### Авлага

/Нэгж: сая төгрөг/

| № | Дансны төрөл     | Дүн     | 2018  |           | Гүйцэтгэл % | 2019 оны төлөвлөгөө |
|---|------------------|---------|---|-----------|-------------|---------------------|
|   |                  |         | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл |             |                     |
| 1 | Дансны авлага    | 1,573.8 |   |           |             |                     |
| 2 | Бусад авлага     | 1,005.5 |   |           |             |                     |
| 3 | Татвар, НДШ, УТТ | 795.6   | Татвар, НДШ-ийн илүү төлөлт болон урьдчилж төлсөн тооцоо дараагийн тайлант хугацаанд суугтан тооцуулна. |           |             |                     |
|   | ДҮН              | 3,374.9 |   |           |             |                     |
|   | Авлагын үлдэгдэл | 3,374.9 | 6,671.0   | 3,374.9   | 197.7%      | 4,535.2             |

Авлага өмнөх оноос 2,748.2 сая төгрөг буюу 21 хувиар буурч, төлөвлөгөө 197.7 хувийн биелэлттэй гарлаа. Үүнд дансны авлага 1,815.9 сая төгрөгөөр, урьдчилж төлсөн зардал 352.9 сая төгрөгөөр, бусад авлага 484.6 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

### Богино хугацаат өр төлбөр

/Нэгж: сая төгрөг/

| № | Дансны төрөл          | Дүн     | 2018   |           | Гүйцэтгэл % | 2019 оны төлөвлөгөө |
|---|-----------------------|---------|--|-----------|-------------|---------------------|
|   |                       |         | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл |             |                     |
| 1 | Дансны өглөг          | 2,249.9 |  |           |             |                     |
| 2 | Урьдчилж орсон орлого | 589.4   | Хэрэглэгчээс орж ирсэн урьдчилгаа төлбөр тайлант хугацаанд нь орлогоор тооцно. |           |             |                     |
|   | ДҮН                   | 2,839.3 |  |           |             |                     |
|   | Авлагын үлдэгдэл      | 2,839.3 | 3,071.0  | 2,839.30  | 108.16%     | 3,081.60            |


Өглөг өмнөх оноос 420.7 сая төгрөгөөр буюу 17 хувиар өсч, төлөвлөгөөний биелэлт 108.2 хувьтай байна. Үүнд дансны өглөг 56 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлого 158.5 сая төгрөгөөр өссөн зэрэг нь нөлөөлжээ.

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

#### Нийгмийн хариуцлагын үзүүлэлтүүд

| Үзүүлэлтүүд   | 2017      | 2018      |
|---|-----------|-----------|
| Ажиллагсдын тоо   | 768       | 771       |
| Хөдөлмөрийн зардал, мян.төг   | 6,555,552 | 6,431,729 |
| Сургалт, хөгжилд зарцуулсан хөрөнгө, мян.төг  | 20,658    | 20,528    |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо  | 3,982     | 3,986     |
| Нийгэм рүү чиглэсэн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, мян.төг                         | 600       | 11,520    |
| Экологийн хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, мян.төг                                       | 150       | -         |
| Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг хангахад зарцуулсан хөрөнгө, мян.төг           | 41,696    | 63,493    |
| Улсад төлж буй татвар, бусад шимтгэл, мян.төг   | 713,659   | 721,840   |
| Мэргэжлийн холбоод, нийгмийн сайн сайхны төлөөх байгууллагын гишүүний төлбөр, мян.төг | 3,455     | 14,496    |

## Ур чадвар, сургалт



✚ Ажлын хариуцлага, идэвхи санаачилга, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд аттестатчиллыг батлагдсан журмын дагуу зохион байгуулж, Улаанбаатар хотын нийт 136 ажилтныг аттестатчилалд хамруулсан.

✚ Компанийн хэмжээнд хууль эрх зүй, дотоод журам, шинэ техник, технологи, дижитал маркетинг, хэрэглэгчээ сонсох, хамт олны уур амьсгалыг сайжруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр нийт 46 сургалт

явуулж давхардсан тоогоор 322 ажилтан хамрагдлаа.

- ✚ Дотоод сургалтаас гадна гадаад улсад Өргөн зурвасны сүлжээний технологи, шийдлүүд, GPON Project Training Schedule сэдэвт сургалтуудад ажилчидтай гэрээ байгуулан хамруулсан.

### Байгууллагын соёл, засаглалыг сайжруулах талаар:

Хүний нөөцийн хөгжил, компанийн засаглалыг сайжруулах чиглэлд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

- ✚ 2018 онд нийт ажиллагсдын үндсэн цалинг 15 хүртэл хувиар нэмэгдүүлсэн.
- ✚ Түүнчлэн МЦХ ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, бизнесийн төлөвлөгөөт зорилтыг хангахад ажилтнуудын ур чадвар, мэдлэг мэргэшил, сэтгэл ханамжийг дээшлүүлж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний системийг хөгжүүлэх зорилгоор ажилчдын дунд аттестатчилал явуулж, 14 ажиллагсдын цалинг нэмэгдүүллээ.
- ✚ Батлагдсан 31 сургалтын дагуу 24 сургалтыг зохион байгуулсан, үүнээс 7 сургалтад давхардсан тоогоор 52 ажилтан хамрагдсаны 96% нь сэтгэл ханамж "сайн" гэж үнэлгээ өгсөн нь сургалтын өгөөж нэмэгдэж байгааг харуулж байна.
- ✚ Ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, дэмжих, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг ашиглах зорилгоор 2018 онд 12 ажиллагсадтай контрактын гэрээ байгуулж ажилласан.
- ✚ Ажлын байрны сахилга, дэг журам, цагийн бүртгэл, түүнд тавих хяналт, цаг бүртгэлийн системийн ашиглалтыг сайжруулахад 16 аймаг, дүүргийн Холбооны газруудад цаг бүртгэлийн төхөөрөмж суурилуулан, компанийн мэдээллийн технологийн дотоод сүлжээнд холбож, хяналт тавин ажиллаж байна.
- ✚ Компанийн өмчлөлийн байранд амьдардаг 2 ажилтанд орон сууцыг нь үлдэгдэл өртгөөр борлуулах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж, тухайн 2 ажилтанд орон сууцыг шилжүүлсэн. Мөн “Орон сууцны зээлийн санг хуваарилах, хүүгүй зээл тусламж олгох журам”-ын дагуу олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа 2 ажилтанд нийт 10 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олголоо.

Компанийн нийт 1,167 ахмад холбоочдыг идэвхтэй амралт, сар шинийн бэлэг, хүндэт холбоочдын тэтгэмж, буцалтгүй тусламж зэрэгт 2018 онд 69.5 сая төгрөгийн тэтгэмжийг олгон, 15 ахмад холбоочдыг 670 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.

## Олон нийтийн үйл ажиллагаа

Мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарын томоохон үзэсгэлэн экспонд бүрэн хамрагдаж, хийж бүтээж, үргэлжлүүлэн төлөвлөж буй үйл ажиллагааныхаа талаар хэрэглэгчид, харилцагчид, салбарын хамт олондоо танилцууллаа.

### 5 дугаар сард

“Төрийн өмчийн менежмент: Нийгмийн хариуцлага” үзэсгэлэн экспод оролцлоо.



### 9 дүгээр сард

ICT экспо үзэсгэлэнд амжилттай оролцож, +1 хөтөлбөрийг танилцууллаа.

### дугаар сард

Архангай аймгийн төвд зохион байгуулагдсан Мэдээлэл харилцаа холбооны салбарын бүсийн зөвлөгөөнд оролцлоо.





## КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн Газар болон БНСУ-ын Кореа телеком корпорацийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны **40** хувийг /**10,348,111** ширхэг хувьцаа/ Монгол Улсын Засгийн газар худалдан авах арилжаа 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр боллоо. Уг арилжаагаар Монгол Улсын Засгийн газар Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа худалдан авсан тул Монгол Улсын Засгийн газар Компанийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн хувиас бусад хэсгийг худалдан авах тендер санал гаргаж 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр нийт **7,572** ширхэг хувьцааг худалдан авсан байна.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны **94.7** хувь буюу **24,499,287** ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, **5.3** хувь буюу **1,370,989** ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.



НИЙТ ХУВЬЦААНЫ  
ТОО

25,870,276


НИЙТ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧИЙН ТОО

3,947

### Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

| №  | Нэр                        | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшиж буй хувьцааны хувь |
|----|----------------------------|---------------------------|----------------------------|
| 1. | Монгол Улсын Засгийн Газар | 24,499,287                | 94.7                       |

### Ханшийн статистик



Эх сурвалж: МХБ

### **НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ**

Монголын цахилгаан холбоо ХК нь Компанийн тухай хуулийн дагуу болон компанийн дүрмийн дагуу компанийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахдаа дараах нөхцлийг биелүүлсний дараа хуваарилдаг. Үүнд:

1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуульд заасан доод хэмжээнээс их байх;
3. Компани эргүүлэн авах үүрэгтэй хувьцааг бүрэн авсан байх;

Дараах шалтгаануудын улмаас 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар МЦХ ХК-ийн ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн төлбөрийн болон хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд буурах хандлагатай байгаа.
2. 2018 оны хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг хадгалах шаардлага тулгарсан.

**Монголын цахилгаан холбоо ХК**  
**2019 он.**